



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 - № 3/358
танай _____ -ны № _____ -т
Аудитын гэрчилгээ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЪЯА
“ГОРХИ-МЭЛХИЙ ХАД” АМРАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.НАНСАЛМАА ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гаалийн ерөнхий газрын харъяа “Горхи-Мэлхий хад” амралтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Гаалийн ерөнхий газрын харъяа “Горхи-Мэлхий хад” амралтын газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гаалийн ерөнхий газрын харъяа “Горхи-Мэлхий хад” амралтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

В. М. /Signature/

Ц.НАРАНЧИМЭГ



ГЕГ-ЫН ХАРЬЯА "ГОРХИ-МЭЛХИЙ ХАД" АМРАЛТ УТУГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын газрын дарга
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663

Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885
Цахим хаяг:
sambuunyamy@audit.gov.mn

Аудитор: Б.Баярмаа
Утас: 260512
Цахим хаяг:
bayarmaab@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Засгийн газрын IV
байр, Бага тойруу-6, УБ-46
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

2017 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго,үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг түвшин
6. Дотоод хяналт
7. Шилэн дансны мэдээлэл
8. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
9. Шилэн дансны мэдээлэл
- 10.Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
- 11.Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
- 12.Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
13. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
14. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
15. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
16. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
17. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
18. Зөвлөмж
19. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Горхи-мэлхий хад" амралт УТҮГ -ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2017/244/СТА-ТШЗ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

"Горхи-мэлхий хад" амралт УТҮГ -ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

"Горхи-мэлхий хад" амралт УТҮГ-ын удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь хөндлөнгийн аудитын байгууллагын үүрэг юм.

"Горхи-мэлхий хад" амралт УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дугаар сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн "Нью диал Аудит" ХХК-ийн захирал, аудитор Э.Эрдэнэбат ахалж, аудитор, аудиторов туслах Э.Эрхэмбаяр нар гүйцэтгэв. /ТАБ-СТА-А-8/

"Горхи-мэлхий хад" амралт УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 3-нд "Нью диал Аудит" ХХК-д ирүүлсэн байна.

"Нью диал Аудит" ХХК нь аудитыг 2017 оны 2 дугаар сарын 05-наас 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд ГЕГ-ын харьяа "Горхи-мэлхий хад" амралт УТҮГ -ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

"Горхи-мэлхий хад" амралт УТҮГ -ын удирдлага нь Монгол улсын "Төсвийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго,үйл ажиллагаа:

"Горхи-Мэлхий хад" амралтын газар нь 2002 онд ГЕГ-ын даргын 2002 оны 602 тоот тушаалаар анх байгуулагдсан. 2006 онд "Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ болон зохион байгуулагдаж амралтын үйл ажиллагаа явуулж ирсэн Сангийн яам, ГЕГ-ын ажилчдын амралтын газар юм. Амралтын газрын зорилго нь харьяа яам, газрын ажилтнуудын ая тухтай амрах нөхцлийг бүрдүүлэх явдал юм. Гэвч амралтын газар нь байгуулагдсан цагаас хойш хөрөнгө оруулалт огт хийгдээгүй, өөрийн хөрөнгө нь хуучирч муудсан, ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна. 2014.06.07 өдрийн 183 тоот тогтоолоор дуудлага худалдаагаар худалдах, төрийн өмчийн хорооны 2014.08.08 өдрийн 4/2190 тоот албан бичгээр итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж зарагдах хүртэл хөрөнгийн хөдөлгөөн хийхгүй хамгаалж, хадгалах чиглэл өгсөн юм байна.Тэмдэглэлт баяр ёслолын үеэр СЯ, ГЕГ-ын ажилтнууд амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 50%-ийн хөнгөлөлттэй нөхцлөөр амардаг боловч сүүлийн жилүүдэд амралтын байр савны нөхцөл байдлаас шалтгаалаад амрагчдын тоо эрс багассан байна. Уг амралтын газар нь 2016 оны тайлангийн жилд 3500 хүнд амралтын үйлчилгээ үзүүлсэн нь 2015 онтой харьцуулвал 27%-иар буюу 1300 хүнээр буурсан байна. "Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар "Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, орлого зардлын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5-1/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 9-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг НББ-ийн тухай хууль, НББОУС, СТОУС-тай нийцүүлэн боловсруулан мөрдөж ажиллаж байна.

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах

аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг "Unicus" санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдал:

Төлөвлөлтийн үе шатанд материаллагын түвшинг тогтоохдоо урьдчилсан байдлаар борлуулалтын орлогоос нь 1%-иар бодож 0,7 сая төгрөгөөр тооцож байсан. Харин гүйцэтгэлийн үе шатанд 2016 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн цэвэр борлуулалтын орлогын дүнгээс нь 1%-иар тооцож 0,8 сая төгрөгөөр шинэчлэн тогтооход материаллагын түвшин 0,07 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. "Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын "Өмч хамгаалах зөвлөл"-өөс хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтанд байнгын хяналт тавьж ажилладаг байна. 2016 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогод "Өмч хамгаалах зөвлөл"-ийн гишүүд хамрагдаж актлах хөрөнгийн жагсаалтыг гаргаж, тооллогын бүртгэлд тайлагнасан байна.

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ нь 2016 оны тайлангийн жилд 79,7 сая төгрөгийн бараа үйлчилгээний орлого, 4,0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого олж 103,4 сая төгрөгийн зардал гаргаж харилцах дансандаа 1,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 19,8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны мэдээллийг оруулах админ эрх авч сар бүр ГЕГ-ын "shilen dans" сайтад санхүүгийн үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг үнэн зөв, бодитой, тогтмол байршуулж хэвшсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал:

Аудитын гүйцэтгэлийн ажлын явцад хэрэгжүүлсэн 9 сорилоос 8 сорил нь холбогдох батламж мэдэгдлүүдийг хангаж үлдэх 1 сорил нь зарим батламж мэдэгдлүүдийг хангахгүй байв.

Бараа материалын жилийн эцсийн тооллогын бүртгэлийг тулган шалгахад бараа материалын дансанд хөрөнгийн чанартай бараа материал бүртгэлтэй байгаа нь санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, хамааралтай байх, иж бүрэн байх, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад орлого, авлага, өглөгийн дансуудад ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны сорилоор: Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 0,056 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,6 сая төгрөг байгаа нь харилцах дансны банкны үлдэгдлийн баталгаагаар 0,1 сая төгрөг нь, бэлэн мөнгөний тооллогын бүртгэлээр 1,5 мянган төгрөгийн үлдэгдэл нь, мөн мөнгөн хөрөнгийн журналын дүнтэй тохирч байна.

Үндсэн хөрөнгийн дансны сорилоор: Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 714,6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 718,5 сая төгрөг байгаа нь хөрөнгийн тооллогын бүртгэлтэй тохирч байна. Тайлант хугацаанд ГЕГ-аас 4,0 сая төгрөгийн уурын тогоо авч хөрөнгийн орлогоор бүртгэсэн байна.

Бараа материалын дансны сорилоор: Бараа материалын дансны эхний үлдэгдэл 15,4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 12,4 сая төгрөг байгаа нь бараа материалын тооллогын бүртгэлтэй тохирч байна. Тайлант хугацаанд өөрийн хөрөнгөөр 12,5 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авч 12,3 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 3,2 сая төгрөгийн бараа материал акталсан нь баримуудаар нотлогдож байна.

Орлогын дансны сорилоор: Үндсэн үйл ажиллагааны орлого 72,9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 6,8 сая төгрөг, ГЕГ-ын хөрөнгийн орлого 4,0 сая төгрөг бүгд 83,7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Өглөгийн дансны сорилоор: Оны эхний үлдэгдэл 31,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 30,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 0,9 сая төгрөгөөр буурсан байна. Нийт өглөгийн 87,6%-ийг татварын хяналт шалгалтын актын өглөг эзэлдэг байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад дотоод хяналттай холбоотой материаллаг бус дараах алдаа илэрсэн. Үүнд:

Бараа материалын дансанд хөрөнгийн чанартай 9 нэр төрлийн 1,250 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна. Энэ нь хөрөнгийг үнэгүйдүүлэх, ашиглал үүсэх нөхцөл болно

Шийдвэрлэсэн:

- 2017 оны хагас жилийн санхүүгийн тайлангаар бараа материалын дансны КТ-ээс үндсэн хөрөнгийн дансны ДТ-д 1,25 сая төгрөгийн бичилт хийж залруулах талаар зөвлөмж өгөх.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 2016 оны санхүүгийн тайланд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын хувьд анхаарал татахуйц асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар бүртгэлийн холбоотой зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийн арилгуулахаар зөвлөмж өгч ажиллалаа.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг "Мишээл-Од Аудит" ХХК хийж гүйцэтгэсэн байна. Аудитаар 4 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт 75,0%-ийн биелэлттэй байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг "Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын даргын 01 тоотор хүлээн авлаа. Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 4 зөвлөмжөөс хэрэгжээгүй 1 зөвлөмжийн утга нь УТҮГ-ыг НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх тухай зөвлөмж байсан учраас хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.САМБУУНЯМ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Э.ЭРДЭНЭБАТ

**ГЕГ-ЫН ХАРЬЯА
"ГОРХИ-МЭЛХИЙ ХАД"
АМРАЛТ УТҮГ-ЫН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1	
Бараа материал.....	3

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг "Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг. ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллагаас гаргасан энэхүү зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан "Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Бараа материал	Тэргүүлэх ач холбогдол №1
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Бараа материалын жилийн эцсийн тооллогын бүртгэлийг тулган шалгахад бараа материалын дансанд хөрөнгийн чанартай насос, цахилгаан харуул, зүлгүүр, сейфтэй хөрөө...гм 9 нэр төрлийн 1,25 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байгаа нь НББОУС 2 "Бараа материал"-ыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

2017 оны хагас жилийн санхүүгийн тайлангаар бараа материалын дансны КТ-ээс үндсэн хөрөнгийн дансны ДТ-д 1,25 сая төгрөгийн бичилт хийж залруулах

Эрсдэлүүд

Бараа материалын ашиглал үүсэх, бүртгэлээр тавих хяналт алдагдана

Үйлчлүүлэгчийн хариу

2017 оны эхний хагас жилийн тайлангаар зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

"ГОРХИ-МЭЛХИЙ ХАД" АМРАЛТ УТҮГ-ЫН ДАРГА Ц.НАНСАЛМАА ТАНАА

Аудитын гэрчилгээ

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Үндэсний аудитын газраас аудит хийв.

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, УСНББОУС, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь "Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2.23. Удирдлагын болон чанарын дахин хяналт:

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАГНАЛЫН
ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Аудитын нэр: "Горхи-Мэлхий хад" амралт УТҮГ -ын
2016 оны санхүүгийн тайлан

Аудитын код: УАГ-САГ/2017/244/СТА-ГАК-ТӨХЭ

Аудитын багийн нэр: "Ньюдиал Аудит" ХХК

Тайлант жил : 2016 он

№	Аудитыг тайлагнах шатанд бүрдүүлэх баримтын нэр	Хяналт хийсэногноо		Тайлбар
		Анхан шатны хяналт	Хоёр дах шатны хяналт	
1	Аудитын тайлан	✓	✓	
2	Санхүүгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторроор гарын үсэг зуруулахаар бэлтгэсэн Аудитын гэрчилгээ	✓	✓	
3	Менежментийн захидал	✓	✓	
Б 4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан,	✓	✓	
5	Санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай байгууллагын албан бичиг болон санхүүгийн тайлан	✓	✓	
6	Акт, албан шаардлагын төсөл			
7	Хянан удирдах ажилтнуудын үүргийн хэрэгжилт			Байхгүй

Бэлтгэсэн:

Аудитор:

Э.Эрдэнэбат

Анхан шатны хяналт хийсэн:

Аудитын менежер :

Я.Самбууням

Хоёр дах шатны хяналт хийсэн:

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор:

Ц.Наранчимэг

Санхүүгийн тайланд аудит хийх явцад аудиторын өмнө тавигддаг гол зорилго байгууллагын удирдлагаас санхүүгийн тайлангаараа дамжуулан гаргаж ирдэг дараахь мэдэгдлүүдийг нотлоход оршдог:

1.*Оршин байх*:санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх;

Хөрөнгө, өр төлбөр, эзэмшигчийн өмч тухайн хугацаанд бодитойгоор оршин байх тухай мэдэгдэл юм. Энэ мэдэгдэл нь бараа материал, барилга, тоног төхөөрөмж, мөнгөн хөрөнгө зэрэг биет зүйлс төдийгүй дансны авлага, дансны өглөг зэрэг биет бус зүйлд хамаарна.

2.*Эрх ба үүрэг*: санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх;

Тодорхой өдрийн байдлаарх тухайн байгууллагын мэдээлсэн хөрөнгө нь түүний эрхийг, өр төлбөр/эх үүсвэр/ нь түүний үүргийг илэрхийлж буй гэдгийг баталсан мэдэгдэл.

3.*Тохиолдсон байх*:аж ахуйн нэгж, байгууллагад бүртгэгдсэн ажил гүйлгээ буюу үйл явдал нь тухайн тайлант хугацаанд бодитой болж өнгөрсөн байх;

Тохиолдсон байх гэдэг нь худалдан авалт, борлуулалт зэрэг бүртгэгдсэн ажил гүйлгээ нь тодорхой хугацааны явцад бодитойгоор болж өнгөрсөн буюу явагдсан эдийн засгийн үйл явдлыг илэрхийлж буй эсэхийг мэдэгддэг.

4.*Иж бүрэн байх*:аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх;

Тодорхой хугацааны туршид болсон бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн бүх ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлууд нь бодитойгоор бүртгэгдсэн эсэхийг харуулсан мэдэгдэл. Жишээлбэл: худалдан авсан бүх бараа үйлчилгээ нь бүртгэгдсэн байхаас гадна санхүүгийн тайланд тусгасан байх ёстой.

5.*Үнэлгээ*:аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг тайлант хугацаанд "Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимтай" нийцүүлэн зөв үнээр бүртгэсэн байх;

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд нийцүүлэн зөв дүнгээр бүртгэсэн эсэхийг энэхүү батламж мэдэгдэл илэрхийлнэ. Жишээлбэл: үндсэн хөрөнгийн тухайн жилийн элэгдлийн зардал болон үлдэгдэл үнийг түүний түүхэн өртгийг системтэйгээр хуваарилах аргад үндэслэн тооцсон болон худалдааны авлагыг тухайн хөрөнгийн цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлснийг санхүүгийн тайлан харуулна.

6.Хэмжилт:аж ахуйн нэгж, байгууллага ажил гүйлгээ буюу үйл явдал тайлант хугацаанд зөв дүнгээр бүртгэгдсэн ба орлого, зардлыг зөв хуваарилсан байх;

Байгууллага ажил гүйлгээ буюу үйл явдлын гүйцэтгэлд үндэслэлтэй, хүчин төгөлдөр хэмжүүр хэрэглэж зөв дүнгээр бүртгэж, тайлагнасан эсэх талаарх мэдэгдэл юм.

7.Толилуулга ба тодруулга:аж ахуйн нэгж, байгууллагасанхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулж, тайлагнасанбайх.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөв ангилж, тодруулсан эсэх талаарх мэдэгдэл.Жишээлбэл: урт хугацаат өр төлбөрийг барагдуулахдаа эргэлтийн хөрөнгийг ашиглаж болохгүй ба бүртгэлийн бодлогын талаарх санхүүгийн тайлангийн хавсралт мэдэгдэл нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмаар шаарддаг тодруулгыг тусгасан байна.

8.Үнэн зөв байдал: аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэжбайхгэсэнбатламж мэдэгдлүүдийг авч үзнэ.

Үнэн зөв байдлын талаарх мэдэгдэл нь санхүүгийн тайланд тусгасан бүртгэгдсэн ажил гүйлгээний математик тооцооллын зөв байдал болон эдгээр ажил гүйлгээг зөв хураангуйлан ерөнхий дэвтэрт шилжүүлж бичсэнийг илэрхийлнэ.Жишээлбэл: дансны өглөг нь зөв үнэ ба тоо хэмжээ, зөв тооцоолсон нэхэмжлэлд үндэслэж бараа, үйлчилгээний худалдан авалтыг тусгасан гэдгийг санхүүгийн тайлан илэрхийлж байх ёстой.

Санхүүгийн тайлагнал, үйл ажиллагааны үр дүнг үнэн зөв илэрхийлэхийн үндэс нь сайн боловсруулагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг юм. "ШТН" ТӨҮГ-ын тухайд өөрийн байгууллагын онцлогтой уялдуулан боловсруулсан НББ-ийн бодлогын баримт бичиг байхгүй байна. НББ-ийн бодлогын баримт бичиг нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын шаардлагууд, санхүүгийн тайлан нь гадны болон дотоодын хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад нь шаардагдах тухайн байгууллагын санхүүгийн байдал (хөрөнгө, эздийн өмч, өр төлбөр), санхүүгийн үр дүн (орлого, үр дүн), санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт (мөнгөн гүйлгээний) – ийн талаарх мэдээлэл, хөтлөгдөх дансны зааварууд,санхүүгийн тайлгналын зарчмууд,

үйлдвэрлэлийн өртөг зардлыг хэрхэн тооцоолох, хэн хяналтыг хэрэгжүүлэх зэрэг бүртгэлтэй холбоотой асуудлыг өөртөө багтаасан байдаг. НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж, үйл ажиллагаандаа ашигласнаар ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого зарлагыг бодитойгоор бүртгэж, тайлагнах, шийдвэр гаргагч дээд байгууллагынхаа өмнө хүлээсэн үүргийнхээ биелэлтийг хангаж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой.

Эрсдэл

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэл нь санхүүгийн тайлангийн тоон мэдээлэлийг хэрэглэгчид, улмаар удирдлагын шийдвэр гаргалтанд сөргөөр нөлөөлөх магадлалтай

Зөвлөмж:

"Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 18,2-т " Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.

" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

18.2 Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.

20.2.2.аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.

20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;

20 дугаар зүйлийн 20.2.10-д" Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тайланд залруулга хийх " гэж заасныг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх.

**ГЕГ-ЫН ХАРЬЯА "ГОРХИ"МЭЛХИЙ ХАД" АМРАЛТ УТУГ-ЫН
АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

###

төгрөгөөр

№	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Аудит-лагдсан
3.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	5587.80	1555250.00
	Кассад байгаа бэлэн мөнгө		
	Төсвийн харилцах		
3.3	Авлага	0.00	0.00
	Татаас ба санхүүжилтийн орлого		
	Төлбөртэй үйлчилгээний авлага		
	Бусад авалга		
3.4	Урьдчилгаа		
	Урьдчилж гарсан зардал		
3.5	Тусгай зориулалттай материал	0.00	0.00
	Эм боох материал	0.00	0.00
	Дуусаагүй үйлдвэрлэл	0.00	0.00
	Бэлэн бүтээгдэхүүн	651397.36	199840.00
	Бичиг хэргийн материал	1300.00	300.00
	Аж ахуйн материал	13876506.00	11963454.00
	Сэлбэг хэрэгсэл	0.00	0.00
	Түлш, шатах тослох материал	0.00	0.00
	Барилгын засварын материал	0.00	0.00
	Хүнсний материал	458057.23	132218.00
	Малын тэжээл	0.00	0.00
	Баглаа боодол	0.00	0.00
	Бусад хангамжийн материал	420670.00	69920.00
	Мал амьтад	0.00	0.00
	Нөөцийн бараа	0.00	0.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		15413518.39	13920982.00
3.9	Барилга байгууламж	634284051.00	634284051.00
	хуримтлагдсан элэгдэл	-186684721.68	-207802024.68
	Авто тээврийн хэрэгсэл	7579000.00	7579000.00
	хуримтлагдсан элэгдэл	-7579000.00	-7579000.00
	Тоног төхөөрөмж	23180664.00	27139664.00
	хуримтлагдсан элэгдэл	-19381331.81	-21145608.63
	Тавилга, аж ахуйн эд хогшил	33953998.00	33953998.00
	хуримтлагдсан элэгдэл	-32812778.61	-32980378.65
	Зам гүүрийн барилга байгууламж	0.00	0.00
	хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
	Батлан хамгаалах зориулалттай тоног төхөөрөмж	0.00	0.00
	хуримтлагдсан элэгдэл		
	Түүх соёлын дурсгалт зүйлс	0.00	0.00
	хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
	Дуусаагүй барилга	0.00	0.00
	Бусад үндсэн хөрөнгө	15131400.00	15131400.00
	хуримтлагдсан элэгдэл	-15131400.00	-15131400.00
	Програм хангамж	450000.00	450000.00
	хуримтлагдсан элэгдэл	-168750.00	-281250.00
	Бусад биет бус хөрөнгө	0.00	0.00
	хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
	Номын фонд	0.00	0.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		452821130.90	433618451.04
НИЙТХӨРӨНГИЙН ДҮН		468234649.29	447539433.04
4.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
	Богино хугацаат зээл		
	Өглөг	31026844.01	30105092.53
	Урьдчилгаа-төсвийн татаас		
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	31026844.01	30105092.53
	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
	ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	31026844.01	30105092.53
	Засгийн газрын оруулсан капитал		
	Орон нутгийн сан	642361589.25	642361589.25
	Хуримтлагдсан үр дүн	-280618933.97	-300392398.74
	Өмнөх үеийн үр дүн	-280618933.97	-280618933.97
	Тайлант үеийн үр дүн		-19773464.77
	Дахин үнэлгээний сан	75465150.00	75465150.00
	ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН	437207805.28	417434340.51
	ӨР ТӨЛБӨР, ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН	468234649.29	447539433.04
	Нийт хөрөнгө - өр төлбөр, эздийн өмчийн зөрүү	0.00	0.00

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР
АУДИТОРЫН ТУСЛАХ

Э.ЭРДЭНЭБАТ
Э.ЭРХЭМБАР

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

####

№		Үзүүлэлт	Аудитлагдаагүй		Аудитлагдсан	
			Мөнгөн гүйлгээ	Үр дүн	Мөнгөн гүйлгээ	Үр дүн
1	Татаас, санхүүжилтийн орлого	Төвлөрсөн төсвөөс				
2		Орон нутгийн төсвөөс				
3		Хөрөнгийн				
4		үр дүнгийн урамшуулал				
5		Бусад тусгай зориулалтын сангаас	1634688.00		1634688.00	
6	Тусламжийн орлого	ОУ-ын байгууллагын тусламж				
7		Төсөвт байгууллагаас				
8		нэмэлт данс				
9	Благын өмчтэй холбоотой	үнэ төлбөргүй авсан бараа материал				
10		Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө		3959000.00		3959000.00
11		Үндсэн үйл ажиллагааны орлого	72929900.00	72929900.00	72929900.00	72929900.00
12		Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6780400.00	6780400.00	6780400.00	6780400.00
13	Төлбөртэй үйлчилгээний орлого	Торгууль, төлбөрийн орлого				
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн			81344988.00	83669300.00	81344988.00	83669300.00
1	Цалин хөлс	Цалин хөлс нэмэгдэл урамшил	38838364.80	38083519.23	39469577.80	38083519.23
2		Үндсэн цалин	38838364.80	38083519.23	39469577.80	38083519.23
3		Нэмэгдэл, урамшил				
4		Гэрээт ажлын цалин				
5		Унаа, хоолны хөнгөлөлт				
6		Үр дүнгийн урамшуулал				
1	НДШ	Бүлэг хоёр Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	5039000.00	4328307.09	5039000.00	4328307.09
1	Тогтмол зардал	Байгууллагын тогтмол зардал	16479710	18079710	16479710	18079710
2		Бүлэг гурав Гэрэл цахилгаан	5469710.00	5469710.00	5469710.00	5469710.00
3		Түлш халаалт	8250000.00	9850000	8250000.00	9850000
4		Цэвэр бохир ус	2760000.00	2760000.00	2760000.00	2760000.00
5		Байрны түрээсийн хөлс				
1	Байгууллагын үндсэн үзүүлэлт	Байгууллагын үндсэн үзүүлэлтэй шууд холбогдох	9030340	9356179.23	9030340	9356179.23
2		Бүлэг 4 Хоол	9016990.00	9342829.23	9016990.00	9342829.23
3		Эм	13350.00	13350	13350.00	13350
1	Бичиг хэрэг болон тээвэр холбоо	Бичиг хэрэг болон тээвэр холбоо	670940	671940	670940	671940
2		Бүлэг тав Бичиг хэрэг	77340.00	78340	77340.00	78340
3		ном хэвлэл авах				
4		шуудан холбоо				
5		Тээвэр /шатахуун/ Биеийн тамирын уралдаан тэмцээн	593600.00	593600.00	593600.00	593600.00
6						
1	Эд хогшил, нормын хувцас	Эд хогшил, нормын хувцас	1740620	787070	1740620	787070
2		Багаж хэрэгсэл	1304300		1304300	
3		Тавилга				
4		хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	410820	719720	410820	719720
5		Бага үнтэй түргэн элэгдэх зүйлс	25500	67350	25500	67350
6		Программ хангамж				
7		нормын хувцас зөөлөн эдлэл				
		Томилолт, зочны зардал	3277658	2094527.36	3277658	2094527.36
1		Дотоод албан томилолт				

2	Томилолт, зочны зардал	Бүлэг долоо	Гадаад томилолт /арга хэмжээ/				
3			Оюутны тэтгэлэг				
4			Баяр наадмын зардал				
5			Давтан сургалтын зардал				
6			Төрийн албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх зардал				
7			Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардал				
8			Лист	1634688.00		1634688.00	
9			Шагнал урамшуулал Буфет	1642970	2094527.36	1642970	2094527.36
1	Бусад бараа үйлчилгээний зардал	Бүлэг найм	Бусад бараа үйлчилгээний зардал	4718693.00	30041511.86	4087480	30041511.86
2			Урсгал засвар	766600.00	766600.00	766600.00	766600.00
3			Төлбөр хураамж болон бусад зардал	2978143.00	1921930.00	2346930.00	1921930.00
4			Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ				
5			Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	40950.00	40950.00	40950.00	40950.00
6			Эд хөрөнгийн даатгал				
7			тэтгэмж тэтгэвэр				
8			Нэг удаагийн тэтгэмж урамшуулал				
9			Аудит үйлчилгээний хөлс	933000.00	933000.00	933000.00	933000.00
10			Төвлөрүүлэх шилжүүлэг				
11			БМ-ын гарз		3217352		3217352
			ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ		23161679.86		23161679.86
			ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	79795325.80	103442764.77	79795325.80	103442764.77
			ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1549662.20	-19773464.77	1549662.20	-19773464.77
			ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
			Хөрөнгийн орлого				
			Үндсэн хөрөнгө борлуулсны				
			Бусад хөрөнгө борлуулалтын				
			ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН /4/	0	0	0	0
			Биет ба биет бус хөрөнгө худалдан авах				
			Бараа материал, нөөцийн бараа худалдан авах				
			Хөрөнгийн бусад зардал				
			ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН /5/	0	0	0	0
			ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ /6=	0	0	0	0
			МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТЭНЦЭЛ /7=3-6/	1549662.20	-19773464.77	1549662.20	-19773464.77
			САНХҮҮЖИЛТИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
			Богино хугацаат зээлийн өглөг /цэвэр/				
			Урт хугацаат зээлийн өглөг /цэвэр/				
			САНХҮҮЖИЛТИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	0	0	0
			НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ /9=7+8/	1549662.20	-19773464.77	1549662.20	-19773464.77
			Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5587.8		5587.8	
			Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1555250.00	-19773464.77	1555250.00	-19773464.77

[illegible]

0

АУДИТЛАСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Аудитлагдаагүй					
№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрыни хувь оролцооны нийт дүн
1	2015 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	642361589.25	75465150.00	-280618933.97	437207805.28
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын				0.00
3	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний				0.00
5	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй				0.00
6	Тайлант үеийн үр дүн			-19773464.77	-19773464.77
7	2016 Оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	642361589.25	75465150.00	-300392398.74	417434340.51
Аудитлагдсан					
№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрыни хувь оролцооны нийт дүн
1	2015 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	642361589.25	75465150.00	-280618933.97	437207805.28
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын				0.00
3	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний				0.00
5	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй				0.00
6	Тайлант үеийн үр дүн			-19773464.77	-19773464.77
7	2016 Оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	642361589.25	75465150.00	-300392398.74	417434340.51
ЗӨРҮҮ					
№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрыни хувь оролцооны нийт дүн
1	2015 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	0.00	0.00	0.00	0.00
3	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний	0.00	0.00	0.00	0.00
5	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй	0.00	0.00	0.00	0.00
6	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
7	2016 Оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00

БАТАЛГААЖУУЛСАН:
АУДИТОР
АУДИТОРЫН ТУСЛАХ

Э.ЭРДЭНЭБАТ
Э.ЭРХЭМБАЯР

0.00

0.00

0.00

АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

№		Үзүүлэлт	Тайлант он	Аудитлагдсан тайлант он		
1	Татаас, санхүүж илтийн орлого	Төвлөрсөн төсвөөс	0.0	0.0		
2		Орон нутгийн төсвөөс	0.0	0.0		
3		Хөрөнгийн	0.0	0.0		
4		үр дүнгийн урамшуулал	0.0	0.0		
5		Бусад тусгай зориулалтын сангаас	0.0	0.0		
6	Тусламжийн орлого	ОУ-ын байгууллагын тусламж	0.0	0.0		
7		Төсөвт байгууллагаас	0.0	0.0		
8		нэмэлт данс	0.0	0.0		
9	Благын өмчтэй үйлчилгээний төлбөртэй	үнэ төлбөргүй авсан бараа материал	0.0	0.0		
10		Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө	3959000.0	3959000.0		
11		Үндсэн үйл ажиллагааны орлого	72929900.0	72929900.0		
12		Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6780400.0	6780400.0		
13		Торгууль, төлбөрийн орлого	0.0	0.0		
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН /1/			83669300.00	83669300.00		
1	Цалин хөлс	Цалин хөлс нэмэгдэл урамшил		38083519.23	38083519.23	
2		Бүлэг нэг	Үндсэн цалин	38083519.2	38083519.2	
3			Нэмэгдэл, урамшил	0.0	0.0	
4			Гэрээт ажлын цалин	0.0	0.0	
5			Унаа, хоолны хөнгөлөлт	0.0	0.0	
6			Үр дүнгийн урамшуулал	0.0	0.0	
1	НДШ	Бүлэг хоёр	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл		4328307.09	4328307.09
1	Тогтмол зардал	Байгууллагын тогтмол зардал		18079710	18079710	
2		Бүлэг гурав	Гэрэл цахилгаан	5469710	5469710	
3			Түлш халаалт	9850000	9850000	
4			Цэвэр бохир ус	2760000	2760000	
5			Байрны түрээсийн хөлс	0	0	
1	Байгууллагын үндсэн үзүүлэлт	Байгууллагын үндсэн үзүүлэлтэй шууд холбогдох		9356179.23	9356179.23	
2		Бүлэг 4	Хоол	9342829.23	9342829.23	
3			Эм	13350	13350	
1	Бичиг хэрэг болон тээвэр холбоо	Бичиг хэрэг болон тээвэр холбоо		671940	671940	
2		Бүлэг тав	Бичиг хэрэг	78340	78340	
3			ном хэвлэл авах	0	0	
4			шуудан холбоо	0	0	
5			Тээвэр /шатахуун/	593600	593600	
6			Биеийн тамирын уралдаан тэмцээн	0	0	
1	Эд хогшил, нормын хувцас	Эд хогшил, нормын хувцас		787070	787070	
2		Бүлэг 6	Багаж хэрэгсэл	0	0	
3			Тавилга	0	0	
4			хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	719720	719720	
5			Бага үнтэй түргэн элэгдэх зүйлс	67350	67350	
6			Программ хангамж	0	0	
7			Нормын хувцас зөөлөн эдлэл	0	0	
		Томилолт, зочны зардал		2094527.36	2094527.36	
1	олт, зочны зардал	Бүлэг доо	Дотоод албан томилолт	0	0	
2			Гадаад томилолт /арга хэмжээ/	0	0	
3			Оюутны тэтгэлэг	0	0	
4			Баяр наадмын зардал	0	0	
5			Давтан сургалтын зардал	0	0	
6			Төрийн албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх зардал	0	0	

7	Томил	Бүлэг до	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардал	0	0
8			Лист	0	0
9			Шагнал урамшуулал	2094527.36	2094527.36
1	Бусад бараа үйлчилгээний зардал	Бусад бараа үйлчилгээний зардал		30041511.86	30041511.86
2		Бүлэг найм	Урсгал засвар	766600	766600
3			Төлбөр хураамж болон бусад зардал	1921930	1921930
4			Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	0	0
5			Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	40950	40950
6			Эд хөрөнгийн даатгал	0	0
7			тэтгэмж тэтгэвэр	0	0
8			Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	0	0
9			Аудит үйлчилгээний хөлс	933000	933000
10			Төвлөрүүлэх шилжүүлэг	0	0
11			БМ-ын гарз	3217352	3217352
			ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ	23161679.86	23161679.86
			ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛЫН ДҮН /2/	103442764.77	103442764.77
			ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН /3=1-2/	-19773464.77	-19773464.77
			ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
			Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз /бодит/		
			Хөрөнгө худалсны орлого		
			Үндсэн хөрөнгө худалсны орлого		
			Бараа материал, нөөцийн бараа худалсны олз		
			ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН /4/	0	0
			ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
			Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз /бодит/		
			Хөрөнгө худалсны гарз		
			Үндсэн хөрөнгө худалсны гарз		
			Бараа материал, нөөцийн бараа худалсны гарз		
			Бараа материал		
	Үүнээс		Нөөцийн бараа		
			Хөрөнгийн бусад зардал		
			Ойжуулалтын зардал		
			Геологи хайгуулын зардал		
			Байгаль хамгаалах төслийн зардал		
			Их засварын зардал		
			Хөрөнгийн бусад зардал		
			ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН /5/	0	0
			ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН /6=1-2+4-5/	-19773464.77	-19773464.77

БАТАЛГААЖУУЛСАН:
АУДИТОР

Э.ЭРДЭНЭБАТ

0

Зерүү

3394084342 3394084341.57

1855983211 -1875756675.60

Төсвийн гүйцэтгэлийн тайлан

		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс нэмэгдэл урамшил		0	39469577.80	-39469577.80	#DIV/0!
Бүлэг нэг	Үндсэн цалин		39469577.80	-39469577.8	#DIV/0!
	Нэмэгдэл, урамшил		0.00	0	#DIV/0!
	Гэрээт ажлын цалин		0.00	0	#DIV/0!
	Унаа, хоолны хөнгөлөлт		0.00	0	#DIV/0!
	Үр дүнгийн урамшуулал		0.00	0	#DIV/0!
Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл			5039000.00	-5039000	#DIV/0!
Байгууллагын тогтмол зардал		0	16479710.00	-16479710	#DIV/0!
Бүлэг гурав	Гэрэл цахилгаан		5469710.00	-5469710	#DIV/0!
	Түлш халаалт		8250000.00	-8250000	#DIV/0!
	Цэвэр бохир ус		2760000.00	-2760000	#DIV/0!
	Байрны түрээсийн хөлс		0.00	0	#DIV/0!
Байгууллагын үндсэн үзүүлэлтэй шууд холбогдох		0	9030340.00	-9030340	#DIV/0!
Бүлэг 4	Хоол		9016990.00	-9016990	#DIV/0!
	Эм		13350.00	-13350	#DIV/0!
Бичигхэрэг болон тээвэр холбоо		0	670940.00	-670940	#DIV/0!
Бүлэг тав	Бичиг хэрэг		77340.00	-77340	#DIV/0!
	ном хэвлэл авах		0.00	0	#DIV/0!
	шуудан холбоо		0.00	0	#DIV/0!
	Тээвэр /шатахуун/		593600.00	-593600	#DIV/0!
	Биеийн тамирын уралдаан тэмцээн		0.00	0	#DIV/0!
Эд хогшил, нормын хувцас		0	1740620.00	-1740620	#DIV/0!
Бүлэг 6	Багаж хэрэгсэл		1304300.00	-1304300	#DIV/0!
	Тавилга		0.00	0	#DIV/0!
	хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		410820.00	-410820	#DIV/0!
	Бага үнтэй түргэн элэгдэх зүйлс		25500.00	-25500	#DIV/0!
	Программ хангамж		0.00	0	#DIV/0!
	Нормын хувцас зөөлөн эдлэл		0.00	0	#DIV/0!
Томилолт, зочны зардал		0	3277658.00	-3277658	#DIV/0!
Бүлэг долоо	Дотоод албан томилолт		0.00	0	#DIV/0!
	Гадаад томилолт /арга хэмжээ/		0.00	0	#DIV/0!
	Оюутны тэтгэлэг		0.00	0	#DIV/0!
	Баяр наадмын зардал		0.00	0	#DIV/0!
	Давтан сургалтын зардал		0.00	0	#DIV/0!
	Төрийн албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх зардал			0	#DIV/0!
	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардал		0.00	0	#DIV/0!
	Лист		1634688.00	-1634688	#DIV/0!
	Шагнал урамшуулал Бүфет		1642970.00	-1642970	#DIV/0!
	Бусад бараа үйлчилгээний зардал	0	4087480.00	-4087480	#DIV/0!
	Урсгал засвар		766600.00	-766600	#DIV/0!
	Төлбөр хураамж болон бусад зардал		2346930.00	-2346930	#DIV/0!
	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		0.00	0	#DIV/0!
	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс		40950.00	-40950	#DIV/0!

Бүлэг найм	Эд хөрөнгийн даатгал		0.00	0	#DIV/0!
	тэтгэмж тэтгэвэр		0.00	0	#DIV/0!
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		0.00	0	#DIV/0!
	Аудит үйлчилгээний хөлс		933000.00	-933000	#DIV/0!
	Төвлөрүүлэх шилжүүлэг		0.00	0	#DIV/0!
			0.00	0	#DIV/0!
ДҮН		0	79795325.80	-79795325.80	#DIV/0!
Орлого	Төсвөөс санхүүжих		0	0	#DIV/0!
	Өөрийн орлогоос санхүүжих		0.00	0	#DIV/0!
	Бусад эх үүсвэр		6780400.00	-6780400	#DIV/0!
ЗӨРҮҮ		0	-73014925.8		
Ажиллагсад	БҮГД	0	0	0	
	Удирдах			0	#DIV/0!
	Гүйцэтгэх			0	#DIV/0!
	Үйлчилэх			0	
	Гэрээт			0	#DIV/0!

1038055032
-958259706.11

төгрөгөөр

Тайлбар

[illegible]
